



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 365

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.6, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгалийн түүхийн музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2010 оны 07-11/288, 07-354/1468, 2013 оны 02-07-81/105 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон нийт 2,254,286,700.00 (хоёр тэрбум хоёр зуун тавин дөрвөн сая хоёр зуун наян зургаан мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэтэй, 1,781,759,771.00 (нэг тэрбум долоон зуун наян нэгэн сая долоон зуун тавин есөн мянга долоон зуун далан нэгэн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Байгалийн түүхийн музейн захирал Н.Зоригтбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд музейн зориулалтаар ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000706



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн
365 дугаар тогтоолын хавсралт

Байгалийн түүхийн музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Барилга, байгууламжийн нэр	УБ, ЧД 4-р хороо, музейн барилга	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Гол барилга /Музейн "А" блок/	УБ, ЧД 4-р хороо, музейн барилга	м.кв	4618	1/1/1954	1,573,798,800.00	1,573,798,800.00	-
2	Өргөтгөлийн барилга /Музейн "Б" блок /		м.кв	1247	1/1/1967	680,487,900.00	207,960,971.00	472,526,929.00
НИЙТ ДҮН				5865		2,254,286,700.00	1,781,759,771.00	472,526,929.00
						(хоёр тэрбум хоёр зуун тавин дөрвөн сая хоёр зуун наян зургаан мянга долоон зуун)	(нэг тэрбум долоон зуун наян нэгэн сая долоон зуун тавин есөн мянга долоон зуун далан нэгэн)	(дөрвөн зуун далан хоёр сая таван зуун хорин зургаан мянга есөн зуун хорин есөн)